МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Том. XXIX (300) 2008 65-80

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН”-Ы СУДЛАЛД П.И.КАФАРОВЫН ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Ё.Жанчив*

“Монголын Нууц Товчоон” хэмээх гайхамшигт бүтээл эдүгээ монгол, нангиад, орос, япон, герман, түрэг, франц, перс, англи, чех, мажар, польш, итали, хасаг, испани, маратхи, буриад, халимаг, болгар, солонгос, уйгур, тува зэрэг 22 хэлээр, дэлхийн 26 оронд давхардсан тоогоор 160 шахам удаа хэвлэгдэн гарч орчин цагийн соёлт хүн төрөлхтний хүртээл болсоор байна.

Удахгүй швед, румын, вьетнам хэлээр гарах гэж байна.

“Монголын Нууц Товчоон”-ыг орчуулсан хоёр дахь гадаад хэл нь орос хэл бөгөөд түүнийг Бээжинд сууж байсан Оросын шашны тэргүүн, гарамгай нангиадач П.И.Кафаров (1817-1878) хийж гүйцэтгэжээ. Тэрбээр эл алдарт туурвилыг Европ дахинд анх танилцуулсан гавъяатай билээ.

П.И.Кафаров 1817 оны 9-р сарын 17-нд одоогийн Татарстан улсын Чистополь хотод санваартны гэр бүлд мэндэлжээ. Тэрбээр шашны сургууль, дараа нь Казаний семинар, улмаар Петербургийн шашны Академид суралцсан байна.

1839 онд тэргүүн лам (архимандрит) Поликарп Тугариновын тэргүүлсэн 12 дахь удаагийн шашны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж анх Хятад улсын Бээжин хотноо очиж, тэндээ 1840-1847 онд сууж хятад хэл бичигт нэвтэрхий суралцсан ажгуу. Дараа нь түүнийг 13 дахь төлөөлөгчдийн багийн тэргүүнд дэвшүүлэхээр Поликарп Тугаринов Петербургт дуудсан байна.

П.И.Кафаров 1848 онд шашны тэргүүн лам буюу архимандрит болж 1850-1858 он хүртэл 13 дахь, 1865-1878 оны хооронд 15 дахь номлогчдын тэргүүнээр Хятадад ажиллаж, амьдралынхаа 30 шахам жилийг энэ улсад өнгөрөөжээ. 13 дахь аялалынхаа дараа тэрбээр Ром дахь Оросын Элчин сайдын яамны сүмийн да ламаар хэсэг ажилласан байна. Мөн Оросын Газар зүйн нийгэмлэгийн даалгавраар 1870-1871 онд Уссурийн хязгаарт угсаатны зүй болон археологийн шинжилгээний ангийг зохион байгуулсан аж.

П.И.Кафаров 1878 онд Бээжинд байхдаа хүнд өвчилж, эмч нарын зөвлөснөөр Европоор дамжин Орос орон руугаа тэнгисийн замаар яаравчлан одсон боловч эх

* МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D)

орондоо хүрч чадалгүй 1878 оны 12 сарын 6-нд Марсель хотноо зүрхний дутагдал өвчнөөр таалал төгсчээ.

Тэрбээр "Палладийн систем" хэмээн алдаршсан хятад хэлний авианы галигийн тогтолцоог (pinyin) үндэслэж, "Хятад-орос толь" зохиож[1] , XIII-XIV зууны Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох нангиад хэлний чухал сурвалж бичгүүд болох Чан Чунь бомбын "Баруунш зорчсон тэмдэглэл", "Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл", Жан Дэ-хуйн Монголоор жуулчилсан тэмдэглэл сэлтийг анх удаа оросоор орчуулж, өмнөтгөл, тайлбарын хамт хэвлүүлсэн байна[2].

Гэвч түүний нэрийг монгол судлалд мөнхөлсөн гавъяа нь "Монголын Нууц Товчоон"-ы судлал билээ. П.И.Кафаров "Монголын нууц товчоон"-ыг эн тэргүүнд Европ дахинд танилцуулсан бөгөөд түүний энэхүү гавъяа зүтгэлийг монголч эрдэмтэд үнэлэн тэмдэглэсээр иржээ[3]. Тухайлбал, академич Ц.Дамдинсүрэн; "…Кафаровын Нууц товчооны орос орчуулга бол 1866 онд <<Бээжин дэх оросын шашны төлөөлөгчдийн бүтээл>> гэдэг номын 4 дүгээр ботид хэвлэгдсэн. Энэ бол Нууц товчоог Европт судалсны эхлэлт мөн. Энэ орчуулгад дэлгэрэнгүй оршил ба 660 гаруй үг өгүүлбэрийн тайлбарыг хавсаргажээ. Кафаров, Нууц товчоог монгол эхээс орчуулсан биш, Хятадын товчилсон орчуулгаас дам орчуулсан тул Нууц товчоонд байгаа олон шүлэг энэ орчуулганд цөм орхигджээ. Гэвч Нууц товчооны гол утгыг зөв сайн орчуулжээ" [4] хэмээн тэмдэглэгдсэн буй.

Орос орчуулга

П.И.Кафаров Хятадын эрдэмтэн Жан Му (**張穆** Zhang mu 1805-1849)-гийн 1848 онд хэвлүүлсэн "Монголын Нууц Товчоон"-ы нангиад товч орчуулгыг орос болгон[5] "Старинное монгольское сказаніе о Чингисхане" ("Чингис хааны тухай монгол өгүүллүүд") хэмээн нэрлэж 1866 онд Санкт-Петербург хотноо "Труды членовъ

---

[1] Китайско-русский словарь: В 2-х кн. /Сост. ... архимандритом Палладием и старшим драгоманом имп. дипломат. миссии в Пекине П.С.Поповым, Пекин, 1889

[2] Си ю цзи или Описание путешествия на Запад, "Труды членов Российской Духовной Миссии в Пекине", t. IV, СПб., 1866, сс.261-434; Путевые записки китайца Чжан-дэ-хой во время путешествия его в Монголию в первой половине XIII столетия, "Записки Сибирского Отдела Императорского Русского Географического Общества", кн. 9-10, Иркутск, 1867; Старинное китайское сказание о Чингис-хане. Шэн-ву-цин-чжэн-лу, (Описание личных походов священно-воинственного). Перевод с предисловием и примечаниями, "Восточный сборник", т.1., СПб., 1877;

[3] Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, Нэгдүгээр дэвтэр, УБ., 1957, (159 тал), 44-р тал; Юань-чао би-ши. (Секретная история монголов), 15 цзюаней, том I, текст, Издание текста и предисловие Б.И.Панкратова, М., 1962, (5-19+602 сс), с.14-15; Н.Ц.Мункуев, Китайский источник о первых монгольских ханах, М., 1965, (222сс), 160-161; Ц.Дамдинсүрэн, Монголын нууц товчоо, УБ., 1976, (238 тал), 9-10-р тал; The Secret History of the Mongols. For the First Time Done into English out of the Original Tongue and Provided with an Exegetical Commentary by F.W.Cleaves, vol.I, London, England, 1982, (277 pp), pp.XIII-XVIII…; Д.Цэрэнпил, Б.Сэржав, Монголын нууц товчооны ном зүй, судлалын тойм, УБ., 1990, (127 тал), 71, 92-93,102-103-р тал; Г.Билгүүдэй, Аман уламжлал ба <<Монголын нууц товчоон>>, УБ., 2000, (166 тал), 16-17-р тал; Д.Цэрэнсодном, Монгол уран зохиолын товч түүх (XIII-XX зууны эхэн), УБ., 2002, (477 тал), 153-154-р тал

[4] Ц.Дамдинсүрэн, Монголын уран зохиолын тойм, Нэгдүгээр дэвтэр, УБ., 1957, (159 тал), 44-р тал;

[5] Юань-чао би-ши. (Секретная история монголов), 15 цзюаней, том I, текст, Издание текста и предисловие Б.И.Панкратова, М., 1962, (5-19+602 сс), с.14; Н.Ц.Мункуев, Китайский источник о первых монгольских ханах, М., 1965, (222сс),161;

Російской Духовной Миссіи въ Пекине", ("Бээжин дэх Оросын шашны төлөөлөгчдийн газрын бүтээл") цувралын IV ботид оруулан хэвлүүлжээ[6].
Эл бүтээл нь :
"Предисловіе переводчика" ("Орчуулагчийн өмнөх үг"), (сс. 3-22),
"Текстъ перевода" ("Эх орчуулга"), (сс. 23-160),
"Примечанія" ("Тайлбар"), (сс.161-258),
"Генеалогическая таблица къ сказанію о Чингисхане" ("Чингис хааны тухай өгүүлэл дэх угсаа гарлын хүснэгт") (2 тал) гэсэн бүтэцтэй юм.

"Орчуулагчийн өмнөх үг"-нээ нангиадын түүхэн сурвалжид "Нууц Товчоон"-ы талаар дурдсан тухай, эл зохиолыг анх ямар үсэг бичгээр зохиосон тухай, нэрийн талаар, уламжлагдан ирсэн тухай, Хятадын эрдэмтэн Вань Гуань дай, Цянь да синъ, Сюй сунъ, Чжанъ му зэрэг хүмүүсийн судалгаа, уул зохиолын агуулга, шинж чанар, зохиогч, он цаг, нангиад үсгээр галиглан тэмдэглэсэн онцлог зэрэг "Монголын Нууц Товчоон" судлалын гол гол асуудлыг товч тодорхой авч үзсэн байдаг бөгөөд олон зүйл дээр зөв байр суурь баримталж байсан нь тодорхой. Тухайлбал, анх зохиогдсон бичиг үсгийн талаар; "… Из сих указаний, при сличении их с текстом *Юань чао ми ши*, оказывается, что оригинал её писан был Монгольскими, но не квадратными, а Уйгурскими буквами; что составители руководства, взяв для образца *Юань чао ми ши*, при переводе её, переложили Монгольские слоги условными, однажды на всегда установленными, знаками Китайскими и, перевели Монгольские слова тоже условными и определенными навсегда Китайскими выражениями. Эти условные выражения и знаки они могли заимствовать из переводной литературы времен династии Юань. Таким образом, *Юань чао ми ши* состояла из трёх текстов: Монгольского, писанного Уйгурскими буквами; тонического, представлявшего только звуки Монгольского текста, выраженные условными Китайскими знаками, и наконец Китайского, переводного."[7*], онцлог шинжийн талаар "... Как произведение старинно-Монгольское, она отличается простотою и наивностию, которые трудно отыскать в твореніях Китайских бытописателей. Она преимущественно распространяется о событиях в жизни Чингисхана, до той поры когда он делается единодержавным владыкою степной Имперіи, о дальнейших его завоеніях, за пределами Монголіи, она говорит кратко, далеко не так, как писатели покоренных им стран."[8], зохиогчийн талаар "... Имя автора *Юань чао ми ши* неизвестно. Впрочем, вникая внимательно в рассказ её, я получил убеждение, что она есть дело не одного лица; по видимому люди, бывшие свидетелями самых событий, или жившие не далеко от времен Чингисхана, слагали, каждый, свои

[6] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, сс.3-258
[7] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 5-6
[*]Техникийн боломжоос шалтгаалан П.И.Кафаровын "Старинное монгольское сказаніе о Чингисхане" номоос эшилсэн зүйлүүдийг орчин цагийн орос хэлний зөв бичихзүйгээр сольсон болохыг анхаарна уу.
[8] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258),14

живые предания в общую сумму, которая и излагаема была систематически кистью какого нибудь грамотного Монгола.”[9] гэх мэтчлэн өгүүлжээ.

Төгсгөлд нь “Нууц Товчоон”-ыг орчуулсан зарчмынхаа тухай “... При переводе на Русский язык *Юань чао ми ши*, употреблено было старание сохранить в возможной точности речь подлиника. Я присоединились филологические и другие, какие мог сделать, пояснения для полного уразумения текста, имея в виду не столько соглашение рассказа *Юань чао ми ши* с другими сказаниями, сколько разъяснение рассказываемых в ней событий.”[10] хэмээн өгүүлсэн байх бөгөөд энэ зарчмаа орчуулгадаа тууштай баримталсан болохыг олон арван жишээ баримтаар нутлан харуулж болно.

П.И.Кафаров “Монголын Нууц Товчоон”-ы талаар нангиадын түүхэн сурвалжид анх дурдсан мэдээ хэмээн “Мингийн магад тэмдэглэл” (“**明實錄** Ming shi lu”) гэдэг олон боть номын “Тайзугийн магад тэмдэглэл” (“**太祖實錄** Tai-zu shi-lu”) хэмээх 141-р боть дахь “Хуа-И И-юй толь”-ийг найруулах тухай Хун-у-гийн 15-р оны цагаан сарын улаан нохой өдөр (1382 оны 1 сарын 20)-ийн тэмдэглэлийг оросоор орчуулан оруулсан байна[11].

Түүний орчуулгын онцлогийг харуулахын тулд зарим нэг жишээг доор өгүүлсүгэй. Үүнд:

“Монголын Нууц Товчоон”-ы 1-р зүйлийг “Вначале, предками Монгольского дома были: небом рожденный бурый волк, да сивая лань; сочетавшись между собою, они вместе переплыли воду, называемую *Тэн-йи-си*, достигли вершины реки, называемое *Онан*, и поселились у горы по имени *Бурхан*; здесь они произвели на свете человека, по имени *Батачихан*.”[12] хэмээн орчуулжээ. Үүнийг Дагуурын Цэнд гүн “Erten-ü Yüvan ulus-un ebüged-ün ijaγur anu tngri-eče törügülügsen Börtü čino-a ajuγu. Maral γou-a-luγ-a nökučejü qamtu-bar tenggis usun-i getülejü Onon kemekü mören-ü ekin-dü kürčü irejü Burqan γaldan aγulan-u emün-e nutuγlan saγuju nigen köbegün törüjüküi. Ner-e anu Batu čaγan”[13] хэмээн орчуулсан буй.

9-р зүйлийг орчуулсан нь; “Причиной же перекочевки *Хорилартаймерганя* было то, что когда община его положила запрет на ловлю соболей и белок в урочище *Хоритумадун*, он огорчился этим и услышав, что в горе *Бурхан* звери водятся в изобилии, поднял весь дом свой и перешел к владетелю горы *Бурхан*, по имени *Шиньчибоян*, и таким образом составил особую фамилию *Хорилар*. Вот как и случилось,

---

[9] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258),15-16

[10]Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 21

[11] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 4-5

[12] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 23

[13] Ц.Хандсүрэн, Цэнд гүн ба Монголын Нууц Товчоо, УБ., 1997, (646 тал), 53-р тал

что *Добэнмерган* взял себе в жены *Аланхоа*."[14]. Үнийг Цэнд гүн; "… Гolilardai mergen-ü negüüjü iregsen učir bolbasu γoul tümed-ün γajar-a bulaγ-a kerm-e-ü jerge görügesü-yi öbersed-iyen qoriγlan čaγajilaγdaju angnaju čidaqu ügei-yin tula, maγudalčaju, Burqan γaldan aγulan-a görügesü elbeg kemen sonusču bükü qotalaγar negün, Burqan γaldan aγula-yin ejen Sinči Buyan-i erijü irebe. Egünü učir-a Гolilar obuγtan boljuqui. Dobuu mergen Arun γou-a-yi gergei bolγaγsan anu eyimü bölüge"[15] гэв.

282-р зүйлийн орчуулга; "Сия книга, в большом собрании, в год мыши, в седьмой луне, во время пребывания на реке *Кэрулян*, в урочище *Кодеэарал*, писанием кончена."[16]

Цэнд гүний орчуулсан нь:

" Энэ бичгийг Их хурал хуралдаж байхад хулгана жилийн долоон сард Хэрлэн голын хөдөө арлын Долоон болдог, Шилхэнцэг хоёрын газраа хаан орд бууж бүхийд бичиж дуусгабай"[17]

Дээрх гурван жишээнээс П.И.Кафаровын орчуулгын байдал бага сага тодрох болов уу хэмээн санана.

Тэрбээр зохиолынхоо "Удиртгал" болон "Тайлбар"-ын харьцааны талаар "Настоящее введение к моему переводу может показаться длинным, как и примечания мои к тексту мелочными; но я считаю подобные подробности необходимым условием добросовестного труда и желаю поставить читателя в полную независмость от переводчика."[18] хэмээн тэмдэглэсэн буй.

П.И.Кафаров "Тайлбар"-таа 660 үг, хэллэгийг товч тайлбарлажээ. Эдгээр нь голдуу хятад товч орчуулгын үг, хэллэгийг тайлбарласан хэрэг юм. Жишээ нь:

"1. *Юань чао ди жен цзу*: предками людей династии *Юань*; это, по моему мнению, перифраз переводчиков; далее название *Юань* более не повторяется."[19]

"10. *Таир, Боро*: должно быть масти лошадей. Вероятно, эти кони играли какую нибудь роль в народных преданиях Монголов.[20]

"82. Выражение двумысленно; оно может значить также: <<мои дети еще не подросли де>>; *чжан бу да мо дао*."[21]

---

[14] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 24

[15] Ц.Хандсүрэн, Цэнд гүн ба Монголын Нууц Товчоо, УБ., 1997, (646 тал), 58-р тал

[16] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 160

[17] Ц. Хандсүрэн, Цэнд гүн ба Монголын нууц товчоо-2, УБ., 2002, (232 тал), 231-р тал

[18] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 22

[19] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 163

[20] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, "Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине", Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 164

“97. *Ман шэ*: самый большой змей.”[22]

“100.*Чайлан*: по Монгольски *дзубери-чино*. Перевожу шакалом, по догадке.”[23]

“486. *Фу шен*: духи, дарующие счастье”[24]

“659. *Да цзюй хой чжо*: когда собрались во множстве; во время большого съезда князей и чинов.”[25]

“660. В 1240 году. См. стр. 16 предисловия.”[26] гэх мэтчилэн тайлбарласан байдаг.

Орчуулгын ард хавсаргасан үг хэллэгийн тайлбар нь түүний орчуулгыг үнэн зөв ухааран ойлгоход чухал хэрэглэгдэхүүн болж байгаа билээ.

Эл бүтээлийг 1910 онд Бээжинд дахин хэвлэсэн бөгөөд дараа дараагийн судлаачдад “Монголын Нууц Товчоон”-ыг судлахад нь үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болсоор иржээ. Тухайлбал, түүний орчуулгыг В.В.Бартольд, В.А.Котвич, Б.Я.Владимирцов нар бүтээлдээ ашиглаж байлаа.

Нэрт монголч, нангиадач Н.Ц.Мункуев “...П.Кафаров, как видно из его описания составных частей <<Юань-чао би-ши>> и ссылок на <<Юн-лэ да-дянь>>, безусловно знал о <<монгольском>> тексте памятника, но в комментарии к переводу он, видимо, не имея под рукой, ссылался на работы китайских ученых, в которых цитировались дополнительные собственные имена из монгольского текста”[27] хэмээн тэмдэглэсэнтэй бид бүрэн санал нийлж байна.

Ийнхүү Оросын нэрт дорно дахины судлаач, шашны зүтгэлтэн П.И.Кафаровын “Старинное Монгольское Сказаніе о Чингисхане” хэмээх бүтээл нь “Монголын Нууц Товчоон”-ыг Өрнө дахины уншигчдад танилцуулсан төдийгүй эл дурсгалын судалгааг эхлүүлсэнээрээ үеийн үед дурсагдах гавьяатай билээ.

Бидэнд эдүгээ “Монголын нууц товчоон”-ы Гү Гуань-чи (1776-1835)-гийн, Цянь Да-Синь(1728-1804)-ий, Бао Тин-Бо (1728-1814)-гийн гэсэн үндсэн гурван бичмэл эх уламжлан иржээ. Эдгээрийн нэгийг Хятадын эрдэмтэн Бао Тин-Бо 1805 онд “Юнлогийн их дүрэмлэх бичиг”(“**永樂大典** yong le da dian”)[28]-ээс хуулан авч бусад

---

[21] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 178

[22] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 179

[23] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 179

[24] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 231

[25] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 258

[26] Старинное монгольское сказаніе о Чингисхане, Перевелъ съ Китайскаго, съ примечаніями, Архимандритъ Палладій, “Труды членовъ Російской Духовной Миссіи въ Пекине”, Томъ IV, СПб., 1866, (сс.3-258), 258

[27] Н.Ц.Мункуев, Китайский источник о первых монгольских ханах, М., 1965, (222сс),161

[28] Эл бүтээлийг доктор, профессор Б.Сумьяабаатар “Өнө баясгалант их толь” хэмээн монголчлон нэрлэсэн билээ. (А.Позднеев, Транскрипція палеографическаго текста “Юань-чао-ми-ши”, УБ., 2005,

эхтэй тулган алдаа мадагийг нь шүүжээ. Тэрбээр түүнийгээ 1847 онд Хань Тай-хуад өгч, П.И.Кафаров 1872 онд Хань Тай-хуагаас худалдан авч, 1878 онд Оросын монголч эрдэмтэн А.М.Позднеевийг Бээжинд очиход нь түүнд дамжуулан өгсөн нь эдүгээ Санкт-Петербургийн Их сургуулийн эрдэм шинжилгээний номын сангийн Дорно дахины хэлтэст хадгалагдаж байдаг ажгуу. Эл эхийг профессор П.Пеллио гэрэл зургаар буулган авч судалгаандаа ашиглаж байгаад 1933 онд Бээжингийн номын санд бэлэглэжээ[29].

П.И.Кафаровын энэ эх олон жил нийтийн хүртээл бололгүй хадгалагдаж байсан бөгөөд 1962 онд Зөвлөлтийн эрдэмтэн Б.И.Панкратов өмнөх үг бичин гэрэл зургаар хэвлүүлсэн юм[30].

Б.И.Панкратоваас өмнө XIX зууны сүүлч, XX зууны эхээр "Монголын Нууц Товчоон"-ыг чулуун барын гэрэл зургаар А.М.Позднеевийн орчуулгын хамт хэвлүүлэх гэж хэд хэдэн удаа оролдсон боловч бүтээгүй ажээ[31]

Орос үсгийн галиг, хадмал орчуулга.

П.И.Кафаров 1872 онд Хань Тай-хуагаас "Монголын Нууц Товчоон"-ы нэгэн гар бичмэл хуулбарыг олж аваад түүнийгээ орос үсгээр бүрэн галиглан буулгаж, үг бүрийн доорх нангиад хадмал орчуулгыг оросоор орчуулж хадсан нь хамгийн анхны галиг болсон төдийгүй хятад хэл мэдэхгүй судлаачдад чухал гарын авлага болжээ.

Харамсалтай нь, тэрбээр уул бүтээлээ хэвлүүлж амжилгүй таалал төгссөн бөгөөд эл гар бичмэл одоо болтол нийтийн хүртээл бололгүй гар бичмэлээрээ ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн Санктпетербургийн салбарын хөмрөгт хадгалагдан байдаг ажээ.

Эдүгээ мэдэгдээд буй "Монголын Нууц Товчоон"-ы кирилл, латин, монгол үсгийн бүрэн галигуудыг он цагийн дараалаар дор жагсаавал:

1. П. И. Кафаровын кирилл үсгийн галиг (1872-1878, хэвлэгдээгүй)
2. Э. Хэнишийн латин галиг (1935, 1937, 1962)
3. С. А. Козины латин галиг (1941, 1990)
4. Ш. Куракичийн латин галиг (1942)
5. П. Пеллиогийн латин галиг (1949)
6. Л. Лигетийн латин галиг (1964, 1971)
7. И. дө Рахевильцийн латин галиг (1972)
8. Баярын монгол үсгийн сийрүүлэг болон латин галиг (1981, 1998)
9. Ш. Озавагийн латин галиг болон уйгуржин монгол үсгийн сийрүүлэг (1984-1989)
10. Т. Дашцэдэнгийн латин галиг (1985)

(XVII+112сс.), с.II; Б. Сумьяабаатар, Б. Нарангэрэл, Монголын нууц товчооны толь, УБ., 2008, (LIV+875 тал), V талд үзнэ үү.

[29] Д.Цэрэнпил, Б.Сэржав, Монголын нууц товчооны ном зүй, судлалын тойм, УБ., 1990, (127 тал),71; Д.Цэрэнсодном, Монгол уран зохиолын товч түүх (XIII-XX зууны эхэн), УБ., 2002, (477 тал), 153-154; А.Позднеев, "Транскрипція палеографическаго текста "Юань-чао-ми-ши", Товчит толтыг Б.Сумьяабаатар, Эрхэлсэн Го. Аким, УБ., 2005, (XVll+112сс), с.II

[30] Юань-чао би-ши. (Секретная история монголов), 15 цзюаней, том I, текст, Издание текста и предисловие Б.И.Панкратова, М., 1962, 5-19+602 сс

[31] Д.Цэрэнпил, Б.Сэржав, Монголын нууц товчооны ном зүй, судлалын тойм, УБ., 1990, (127 тал),71

11. Элдэндэй, Ардаажав нарын монгол үсгийн сийрүүлэг (1986)
12. Их мянгадай Иринчиний уйгуржин монгол үсгийн сийрүүлэг (1987)
13. Ш. Гаадамбын монгол үсгийн сийрүүлэг (1990)
14. Б. Сумъяабаатарын монгол үсгийн сийрүүлэг, үсэгчилсэн латин галиг (1990)
15. Ж. Ч. Стритийн латин галиг (1997)
16. Х. Курибаяши, Чойжинжав нарын латин галиг (2001)
17. Шонхорын уйгуржин монгол үсгийн сийрүүлэг болон латин галиг (2002)
18. Ю Вонь-сугийн латин галиг (2004)
19. Ш. Чоймаагийн уйгуржин монгол үсгийн сийрүүлэг (2005)
20. Э. Ардаажавын латин галиг (2005)
21. Пак Вон-гил, Ким Ги-сонь, Чой Хён-вонь нарын латин галиг (2006)
22. Б. Напилын латин галиг (2006)

МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхимийнхэн бид 2007 онд П.И.Кафаровын гар бичмэлийн гэрэл зургийг хүнээс худалдан авсан билээ.

- Эл гар бичмэлд анхнаасаа зүйлийн дугааргүй байсан авч сүүлд нь уг гэрэл зураг дээр хар хөх өнгийн тосон балаар дугаар тавьжээ.
- Энэхүү гар бичмэлийн хар цагаан гэрэл зургаас уул эх нь ямар өнгийн бэхээр бичигдэснийг нь тогтоох боломж алга.
- Орос үсгийн галигийг том үсгээр, орос хадмал орчуулгыг нь үг бүрийн дор арай жижиг үсгээр бичсэн бөгөөд галиг, хадмал орчуулга хоёрыг нийлүүлэн нэг мөр хэмээн тооцвол, нэг нүүрнээ 22 мөр (22×2=44 мөр) бичээстэй юм.
- Тогтуун, гаргац сайтай үсгээр, баллаж сохлолгүй, ихэд нямбай бичжээ.
- Хүний нэр, газар усны нэр сэлтийг орос хадмал орчуулгадаа давтан бичилгүй, хөндлөн зурж товчилжээ.
- Тус галигийн хуудас болгоны баруун дээд талд дугаар тавьсан нийт 260 хуудас бүтээл бөгөөд хуудасныхаа хоёр захаар давхар шугам татаж, голд нь уг зохиолоо бичжээ.
- “Предварительные примечания” гэсэн нүүр хуудасны зүүн баруун, 1-р хуудасны зүүн дээд, баруун доод, 2-р хуудасны зүүн, 15-р хуудасны баруун, 28-р хуудасны зүүн доод, 39-р хуудасны зүүн, 67-р хуудасны зүүн доод, 74-р хуудасны зүүн доод, 131-р хуудасны зүүн, 139-р хуудасны зүүн доод, 143-р хуудасны зүүн, 200-р хуудасны зүүн, 213-р хуудасны зүүн, 214-р хуудасны зүүн, 217-р хуудасны зүүн, 218-р хуудасны зүүн, 219-р хуудасны зүүн дээд, 220-р хуудасны зүүн, 233-р хуудасны баруун доод, 237-р хуудасны зүүн дээд, 238-р хуудасны зүүн, 240-р хуудасны зүүн дээд, 245-р хуудасны зүүн, 256-р хуудасны зүүн дээд, 258-р хуудасны зүүн доод, 260-р хуудасны зүүн талын зайд тус тус тайлбар тэмдэглэл хийжээ.

П.И.Кафаровын энэхүү гар бичмэл орос галиг “Предварительное примечание” (“Урьдчилсан тэмдэглэл”) хэмээх нэг хуудасаар эхэлж байгаа бөгөөд “Монголын Нууц Товчоон”-ы нангиад галиг, хадмал орчуулгынхаа онцлогийн талаар, мөн өөрийн хийсэн ажлын тухай өгүүлжээ. Тухайлбал, “... В настоящем переложении, я ограничился присоединением вариантов в транскрипций монгольских слов и в подстрочном переводе, предоставляя нашим ученым монголистам труд исправления ошибок. -По замечанию здешных монголистов, текст писан разговорным монгольским языком и содержит в себе не мало архаизмов.

Некоторые монгольские слова оставлены мною без перевода, или по-тому, что в копии даже нет его, или потому, что даже перевод явно ошибочен (описка). А.П.” хэмээн тэмдэглэсэн байна.[32]

Үүнээс үзвэл, П.И.Кафаровын энэхүү галиг, орчуулга бол монгол судлаачдаар алдаагаа засуулахаар бэлтгэсэн анхны хувилбар хэмээн үзэж болох буй за.

Сүүлийн 260-р хуудасны төгсгөлд;

“P.S. Писатель копии упоминает, в одной заметке, о печатьном экземпляре транскрипций Монгольского теста; но не видно, чтоб он воспользовался им для проверки своей копий.” хэмээн хэн нэгэн хүн тэмдэглэжээ.[33]

П.И.Кафаровын кирилл галигийн онцлогийг харьцуулахын тулд 185-р зүйлээс багахан хэсгийг таслан авч бусад хүний галигтай зэрэгцүүлэн үзүүлье.

Нангиад галигийн эх:

“王中罕 格捏惕 借 阿勒壇 巾舌兒篾 孛思中合周 中忽舌林剌梅 斡脫舌兒連 亦古勒古周 雪泥惕 都里里格周 樔顛 不赤耶 客額罷。”[34]

1. П.И.Кафаров (1872-1878) : “Ванхань гэнљтъ би алтанъ тљрмљ бэсхачжоу хуриньламуй, окэрлень игулгучжоу сюенитъ дулилигэчжоу нендень бучиљ кээба.”[35]
2. Э.Хэниш (1937): “Ongḫan genet bui. altan terme bosḫaju ḫurimlamui. otorlen igulguju sünit duli duligeju nenden buciye ke’ebe”[36]
3. С.И.Козин (1941): “Van-qan kenet bi. Altan terme bosqaju qurinlamui. Oterlen iqulju, suenit dulilіceju nenden buciye!” ke’eba.[37]
4. Ш.Куракичи (1942): “Waṅ-Qān gened bi. Altan terme bosγažu qurimlamui. Ötörlen igülgüžü sőnid düliligežü nemden büčije” keġebe.[38]
5. П.Пеллио (1949): “Ong-qan gänät büi altan tärmä bosqaju qurïmlamuï. Ötörlän igü1güjü [1] ((1) Corr. nä’ü1gäjü?) sünit düliligäjü [2] (2. Corr.düligäjü?) nändän büciyä kä’äba.”[39]
6. Л.Лигети (1971): “Ong-qan genet büi altan terme bosqaju qurimlamui ötörlen igülgüjü sönit düli dülilgejü nenden büčiye ke’ebe”[40]
7. И.дө Рахевильц (1972): “Ong-qan genet bui altan terme bosqaju qurimlamui ötörlen igülgüjü sönit dülil<i>gejü nenden büciye ke’eba”[41]

---

[32] П. И. Кафаровын гар бичмэл, Нүүр хуудас

[33] П. И. Кафаровын гар бичмэл, 260-р хуудас

[34] **元朝秘史三種, 中文出版社, 京都**, 1975, (815 pp.), 153, 465, 700

[35] П. И. Кафаровын гар бичмэл, 134-р тал

[36] Mangḫol un niuca tobca’an. (Yűan-ch‘ao pi-shi), Die Geheime Geschichte der Mongolen, Aus der chinesischen transcription (Ausgabe Ye Teh-Hui) im Mongolischen Wortlaut Wiederhergestellt von E. Haenisch, Leipzig, Otto Harrassowitz, 1937, (140 ss.), 52

[37] Сокровенное Сказание Монголов. Анонимная монгольская хроника 1240 года. Монгол-ун Нигуча Тобчиян. Юань чао би ши, Элиста, 1990, (280 сс.), 138-139

[38] Sh. Kurakichi, Onyaku-mô̄bun-gencho-hishi. A Romanised Representation of the Yuan-ch’ao-pi-shi (A Secret History of the Mongols) in its Original Mongolian Sound, Tokyo, 1942, 五十 b

[39] P. Pelliot, Histoire secrète des Mongols. Restitution du texte mongol en traduction française des chapitres I a VI, Paris, 1949, (197 ss.), 63

[40] L. Ligeti, Histoire Secrète des Mongols, MLMC, I, Budapest, 1971, (268 pp.), 142

[41] I. de Rachewiltz, Index to the Secret History of the Mongols, Indiana University, Bloomington, 1972, (347 pp.), 94

8. Баяр (1981) : “ūaŋqan kenet' puj, alt'an t'erme posqatʃu qurimlamuj. ot'orlen ikulkutʃu sonit' t'uliliketʃu nent'en putʃije k'e’epe.”[42]
9. Т.Дашцэдэн (1985): “Wang qan gened buy. Altan terme bosqaju qurimlamuy. Ötörlen igülgüjü sönid dülil(i)gejü nenden büčiye keebe.”[43]
10. Ш.Озава (1987) : “Ong qan gened büi, altan terme bosqaju qurimlamui, ötörlen igülgüjü sönid düliligejü nenden büčiye ke’ēbe.”[44]
11. Ж.Ч.Стрит (1997): “O[n≈] qan gene·d~ bü-y; altan terme bos-qa-ju qurimla-muy. Ötörle-n neü1-ge-jü[661] (661. YCPS igülgüjü emended to neülgejü (as Pelliot; i.e igneülgejü); the form in our text apparently resulted from an error in readıng the vertical script from negülgejü (=SH neülgejü); see de Rachewiltz in PFEH 16.65 (1977).) sőni·d dülilge-jü [662] (662. YCPS düliligejü emended to dülilgejü (i.e. dülil<i>gejü). This emendation was made by Pelliot. Haeniseh’s dictionary suggested rather that the form in our text might be = düli düligejü. For the text’s sönid düliligejü we might expect either söni dülilјü (as 2333, 3335) or söni dülildüjü (3338); hence perhaps the seeming d plural here is an error as well as the following verbal form. Note that in YO32 we find söni düliligejü!) nende-n büciye kee-be”.[45]
12. Шонхор (2002) : “ong qan gened bui. altan terme bosqaju qurimlamui. ötörlen igulguju sönid düliligeju nenden büčiye kemebe.”[46]
13. Ю Вонь-су (2004) : “Ong-qan gened bui. Altan terme bosγaju qurimlamui. Ötörlen igülgüjü sönid düliligejü nenden büčiye!” ke’ebe.”[47]
14. Э.Ардажав (2005) : “Ong qan gened bui. Altan term-e bosqajiu qurimlamui. őtőrlen igülgüjiü sönid düliligejiü nenden büčiy-e” ke’eb (a) [e].”[48]
15. Пак Вонь-гил, Ким Ки-сонь, Чой Хён-Вонь (2006): “Ong khan gened büi, altan terme boskhaju khurimlamui, ötörlen igülgüjü sönid düliligejü nenden büčiye ke’ēbe.”[49]
16. Б.Напил (2006) : “Oŋ-qan kenet bui altan terme bosqažu qurimlamui. Ötörlen iqulγužu sünit düliličežü neŋden büčiye ke[g]ebe”[50]

Бусад эрдэмтдийн “qurimlamui” хэмээн галигласан үгийг П.И.Кафаров “хуриньламуй”, С.А.Козин “qurinlamui” хэмээн галигласан нь эл үгийн хоёр дахь ханз буюу “舌林” үсгийг одоогийн Бээжин аялгууны дуудлагаар “lin” хэмээн уншсанаас шалтгаалжээ. Гэтэл энэ ханз “Монгол үсгийн дууриан” (“蒙古字韻 meng gu zi yun”)-д “lim” (Дөрвөлжин үсгээр “ᠯᡳᠮ lim” гэжээ.) гэсэн дуудлагатай байна.[51]

---

[42] Bayar, Mongγol-un Niγuča Tobčiyan, Ded debter, ÖMAKQ, 1981, (395-1099 pp.), 744

[43] Монголын нууц товчоо, Галиглан хэвлүүлсэн Т. Дашцэдэн, Редактор Ц. Дамдинсүрэн, Н. Ишжамц, CSM, t. XXI, f. 1, УБ., 1985, (216 тал), 119

[44] 小沢重男,元朝秘史全釈續攷、上,1987, (630 pp.), 194

[45] The Secret History of the Mongols, Copyright John C. Street 1985-1997, Version 22e, (21 April 1997)

[46] Šonγqor, “Mongγol-un Niγuča Tobčiyan”-u sergügelte, öMAKQ, 2002, (3+73+488+5 tal-a), 246

[47] **元朝秘史, 유원수 역주, 사계절출판사, 2004, (551 pp.), 409**

[48] **阿尔达扎布，新译集注《蒙古秘史》，内蒙古大学出版社, 2005, (870 pp.) , 775**

[49] **박원길, 김기선, 최형원, 몽골비사의 종합적 연구, 민속원, 2006, (472pp.), 216-217**

